

Агуулга

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ

Аудитыг Санхүүгийн хяналт аудитын албаны 2017 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

Санхүүгийн хяналт аудитын албаны

СХШУАБайцаагч

Д.Сарангэрэл

СХШУБайцаагч О.Гантуяа

Уг тайланг СХАА-наас авч үзнэ үү:

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70342244 утасаар харилцана уу

Хаяг:

Санхүүгийн хяналт аудитын алба

Булган 5-р баг

Төрийн захиргааны байр

Өрөө №206 тоот

Булган аймаг

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд

Аудитын стандарт, багийн бүрэлдэхүүн

Байгууллагын талаарх товч мэдээлэл

Бүлэг 1: 12 жилийн 1 дүгээр сургуулийн төсвийн зарцуулалт үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

Бүлэг 2: Санхүүгийн үйл ажиллагаанд дотоодын хяналт шалгалт, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Дүгнэлт:

Зөвлөмж:

АУДИТЫН ТАЙЛАН

2018.02.05

Булган

1. Аудитын нэр:

“12 жилийн нэгдүгээр сургуульд 2016 онд төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт”

2. Аудитын код:

БуАСХАА-/2017/-12-А

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Санхүүгийн хяналт аудитын албаны 2017 оны бүтээгдэхүүн ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн хяналт шалгалтын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

4.Аудитын зорилт:

Аудитын зорилт “12 жилийн 1 дүгээр сургуулийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа” нь төсвийн хөрөнгийн зарцуулалт, ашиглалт, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалт, хадгалалт хамгаалалтанд тавих дотоодын хяналтыг хэрхэн үр ашигтайгаар хэрэгжүүлж ямар үр нөлөөтэй ажилласанд дүгнэлт өгч шаардлагатай бол санал боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэхэд оршино.

-Төрийн үйлчилгээний чанар, тоо хэмжээнд үндэслэн арвилан хэмнэлттэй, үр ашигтайгаар төлөвлөсөн эсэх.

-Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байдал

-Төрийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт хамгаалалт

-Төсвийн хөрөнгийн зарцуулалт

-Хууль тогтоомжийг баримталсан эсэх

5.Аудитын хамрах хүрээ:

12 жилийн 1 дүгээр сургуулийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагааг хамрууллаа.

6.Аудитын арга

Аудитын явцад аудитын олон улсын стандарт, төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, санхүүгийн болон гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, холбогдох асуудлаар аудитад хамрагдсан төсөвт байгууллагын ажилтнуудаас асуулга авах, судалгаанд дүн шинжилгээ хийх зэрэг аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

7. Эрсдлийн үнэлгээ

“12 жилийн 1 дүгээр сургуулийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаа”-г “Дунд” гэж үзлээ.

8.Шалгуур үзүүлэлт

- Төрийн аудитын тухай хууль
- Боловсролын тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засгийн газрын холбогдох тогтоол шийдвэрүүд, хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм журам
- Хууль, тогтоомжийг баримталсан эсэхийг холбогдох санхүүгийн баримт материалтай тулган баталгаажуулах.
- Холбогдох бусад хууль, тогтоомж

9. Аудит хийх багийн бүрэлдэхүүн, хугацаа

Аудитыг Санхүүгийн хяналт аудитын албаны удирдамжаар СХШУАБайцаагч Б.Баттулга, СХШУАБайцаагч Д.Сарангэрэл нар удирдаж СХШУБайцаагч О.Гантуяа 2017 оны 11-р сарын 22-наас эхлэн ажлын 25 хоногт багтаан удирдамжийн дагуу явууллаа.

10. Аудитын тайлан

Аудитын тайлан нь энгийн, тодорхой, хоорондийн уялдаа холбоотой байх бөгөөд ерөнхий зүйл, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, байгууллагуудын дарга, эрхлэгч нарын санал болон хавсралт судалгаа тооцоо, тайлбаруудаас бүрдэнэ.

Аудитын тайлангийн төслийг шалгагдагч байгууллагын удирдлагад танилцуулж, санал авч аудитын удирдагчид танилцуулан баталгаажуулсан.

Үндсэн мэдээлэл:

Булган сумын 12 жилийн нэгдүгээр сургууль нь “Хүүхэд бүрт тав тухтай орчин бүрдүүлж зөв дадал хэвшил, цагийн үр бүтээл, чанартай боловсролыг эрхэмлэн, иргэд олон нийттэй хамтран нээлттэй ажиллах” зорилго тавин ажиллажээ.

2016-2017 оны хичээлийн жилүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрэгжүүлэх, ур чадвар арга зүйгээ сайжруулан суралцагчдад зөв хандлага төлөвшүүлж бүтээлчээр ажиллахад чиглүүлж тусгай төлөвлөгөө гарган хэрэгжилтэнд хяналт тавьж биелэлтийг тооцон ажилласан байна.

Тус сургууль хичээлийн А байр 920 хүүхдийн Б байр 160 хүүхдийн хүчин чадалтай 2 байртай бөгөөд 1397 хүүхдийг 46 бүлэгт хүлээн авч үүнээс бага 21 бүлэгт, дунд 12 бүлэгт, ахлах 13 бүлэгт хамруулсан байна. Дотуур байранд дунджаар 232 сурагч амьдарч, 74 багш сурган хүмүүжүүлэгч, захиргаа аж ахуйн 35 бүгд 109 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулсан байна.

1.1 Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй, хичээл үйлдвэрлэлийн зардлаас өр авлагад тусгаагүй шагнал, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс авсан, цалингийн урьдчилгааг тооцооны дансаар дамжуулдаггүй, шууд зардалд тусгасан байна.

Булган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 2-р хуралдааны 2016 оны 12-р сарын 15-ны өдрийн 06 дугаар тогтоолоор тусгай зориулалтын шилжүүлгээр бүрэн дунд сургуулийн зардлыг 1643850.1 мянган төгрөгөөр төлөвлөн санхүүжихээс 1643850.1 мянган төгрөгөөр санхүүжин өөрийн орлогыг 5307.7 мянган төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 5310.0 мянган төгрөгийг төсөвт оруулж төсвийн санхүүжилтээс 21080.7 мянган төгрөгийг хэмнэн Төсвийн тухай хуулийн 7.7 дахь заалтын дагуу татан төвлөрүүлсэн байна.

Өөрийн орлогоор туслах аж ахуйгаас махны үнэ 4543.0, тодорхойлтны үнэ 10.0 мянган төгрөг, усны үнэ 387.0 мянган төгрөг, заалны орлого 66.0 мянган төгрөг, парны үнэ 133.0 мянган төгрөг, байрны түрээс 180.0 мянган төгрөг нийт 5310.0 мянган төгрөгийн орлогыг оруулсан байна.

Тус сургууль нь 2016 онд 109 багш ажилчидтай 1397 суралцагчтай үйл ажиллагаагаа явуулж, цалингийн санд 969065.0 мянган төгрөгийг төлөвлөн гүйцэтгэлээр 955945.1 мянган төгрөгийн цалин олгожээ. **Цалингийн урьдчилгааг тооцооны дансаар дамжуулдаггүй, шууд цалингийн зардалд хааж бичдэг.**

Монгол улсын Засгийн газрын 2013 оны 393 дүгээр тогтоолоор улирлын ажлын үр дүнгээр олгодог мөнгөн урамшууллыг олгохдоо ажлыг дүгнэн захирлын тушаалын дагуу 1-р улиралд 103 албан хаагчдад 10-45 хувиар 20348.3 мянган төгрөг, 2-р улиралд 103 албан хаагчдад 25-45 хувиар 18261.3 мянган төгрөг, 3-р улиралд 84 албан хаагчдад 4-45 хувиар 12253.8 мянган төгрөг, 4-р улиралд 106 албан хаагчдад 15-45 хувиар 25003.2 мянган төгрөгийн урамшууллыг олгосон байна.

Мөн дээрх тогтоолоор тус сургуулийн захирал нь ажлаа дүгнүүлэн Аймгийн Засаг даргын 2016 оны 04 сарын 06-ны А/142 тоот захирамжаар 1-р улиралд 45% буюу 330.3 мянган төгрөг, 2016 оны 06 сарын 30-ны А/307 тоот захирамжаар 2-р улиралд 45% буюу 330.3 мянган төгрөг, 2016 оны 10 сарын 17-ны А/451 тоот захирамжаар 3-р улиралд 45% буюу 330.3 мянган төгрөг, 2016 оны 12 сарын 20-ны А/545 тоот захирамжаар 4-р улиралд 45% буюу 330.3 мянган төгрөг нийт 1321.2 мянган төгрөг, мөн Засаг даргын 2016 оны 05 сарын 27-ны А/257 тоот захирамжаар ур чадварын нэмэгдлийг 25%-иар 6-12 сард нийт 1042.7 мянган төгрөгийг олгосон байна.

Боловсролын тухай хуулийн 43.1-ийн 4. 1-7-д заасны дагуу тасралтгүй 5 жил ажилласан 13 багшид 43011.8 мянган төгрөгийг олгосон байна.

Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.3 дахь “Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь

төсвийн байгууллагаас ирүүлсэн 10 сая төгрөг хүртэлх зохицуулалт хийх хүсэлтийг судлан, зөвшөөрөгдсөн зардлын бүлэг хооронд зохицуулалтыг хийж, бүртгэн баталгаажуулна” гэсэн заалтыг зөрчин сургуулийн захирлын тушаалаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас шагнал урамшуулалд 380.0 мянган төгрөг, урьд оны багш нарын баярын шагналд 301.7, ахмадын баярын үйл ажиллагаанд 1374.6 мянган төгрөг, шинэ жилийн баярт зориулан ёлканы тоглоом, саанд 118.0 мянган төгрөг, шаар 24.0 мянган төгрөг, нэг бүр нь 570.8 төгрөгийн үнэтэй нийт 797.4 мянган төгрөгийн бэлэг авч сургуулийн бүх сурагчдад өгсөн нь Монгол Улсын засгийн газрын 2014 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 147 тоот “Төсвийг хэмнэлтийн горимд шилжүүлэх зарим арга хэмжээний тухай” тогтоолын 4. дэхь “баяр ёслол, байгууллага, салбарын ой, тэмдэглэлт өдөр зохион байгуулахтай холбогдуулан төсвийн хөрөнгөөр цаасан мэндчилгээ илгээх, бэлэг дурсгалын зүйлс, цүнх, календарь зэрэг зүйлс бэлтгэх, ивээн тэтгэхийг хориглосугай.” гэснийг хэрэгжүүлэн ажиллаагүй. Мөн бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс буюу 132.0 мянган төгрөгийн үнэтэй 4ш ус буцалгагч, 4ш усны сав, 26.0 мянган төгрөгийн биеийн жин, 120.0 мянган төгрөгийг теннисний аркет, 50.0 мянган төгрөгийн телевизор тогтоогч, 374.0 мянган төгрөгийн бөмбөг, 180.0 мянган төгрөгийн мөнгөн аяга, 275.0 мянган төгрөгийн мауз, 589.4 мянган төгрөгийн сагс, волейбол, гандболын бөмбөг тус бүр авч зарцуулсан нь Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг хэрэгжүүлэн ажиллаж хичээл үйлдвэрлэлийн зардлаас зориулалт бус зардал гарч болзошгүй байгааг анхаарах шардлагатай байна.

Нярав М.Ганчимэгийн нэхэмжлэлтэй шүүх хуралд хариуцагчаар орж өмгөөлөгчийн хөлсөнд 500.0 мянган төгрөг, тэмдэгтийн хураамжинд 40.7 мянган төгрөгийг бусдаар гүйцэтгүүлэх зардлаас зарцуулсан.

Шатахууны тайланг сар бүр гаргаж жолоочийн тооцооны хуудас хөтөлдөг ч шатахуунд олгосон мөнгөн дүнг л бичиж зарцуулдаг тухайн машины түлш зарцуулах норм, хэдэн км явсан, шатахууны зарцуулалт зэрэг мэдээллийг оруулдаггүй, тооцоог хийдэггүй байна.

2016 оны 05 дугаар сарын 31-нд Сайхан монгол ТББ-аас 80.0 мянган төгрөгийн модем худалдан авсан ч материалын тайланд орлогодоогүй тайлан бүртгэлд тусгаагүй байна.

Нярав М.Түвшинбаярын Хаан банкны 5270334063 тоот дансаар нийт 3762.6 мянган төгрөгийн гүйлгээ хийсэн ч бэлэн мөнгөний тайлан гаргаагүй байна.

Санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн тайлан ТБСТТ-1-д тоног төхөөрөмж 32770.1 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 9282.8 мянган төгрөг, орон сууцны барилга 1422200.0 мянган төгрөг, биет бус хөрөнгө 250.0 мянган төгрөг нийт 1464502.9 мянган төгрөгийн хөрөнгө орлогод авсан байхад тооллогын комиссын илтгэх хуудсанд 51251.9 мянган төгрөгийн хөрөнгө шинээр нэмэгдсэн гэж илтгэсэн байна. Үүнээс дүгнэхэд байгууллагын тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг нэр төдий эд хөрөнгө ашиглалтын картан дээрх хөрөнгийг тулгалт хийж, шинээр нэмэгдсэн хөрөнгийг хагас дутуу тоолсон байна.

Тус сургууль нь аж ахуй материалын дансанд 373.9 мянган төгрөгийн хувилагч канон, 345.0 мянган төгрөгийн үнэтэй хивс, мөн 45.0 мянган төгрөгийн үнэтэй 40 ширхэг

нийт 1800.0 мянган төгрөгийн сурагч ширээ сандал гэх зэрэг үндсэн хөрөнгийг бараа материалын үлдэгдлээр тусгаж тайлагнан НББОУС-16-г зөрчсөн байна.

НББОУС-16-д “Үндсэн хөрөнгө гэж дараахь шалгуурыг хангасан хөрөнгийг хэлнэ а/ үйлвэрлэл, борлуулалт, үйлчилгээ, түрээс эсвэл удирдлагын хэрэгцээнд ашиглаж байгаа б/ нэгээс дээш тайлант хугацаанд ашиглагдах” хөрөнгийг хэлнэ гэж заасан. Байгууллагын хөрөнгийн бүртгэл тооллогыг чанартай гүйцэтгэж хөрөнгийг зөв ангилан бүртгэл тайланд тусгах нь зүйтэй байна.

1.2 Дотуур байрны хүүхдийн өдөрлөгийг 39 хүүхдээр илүү тооцож 90.3 мянган төгрөгийн хүнс илүү зарлагадсан.

Дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 102099.1 мянган төгрөгөөр төлөвлөж 42858 хүүхэд өдөрт 102066.7 мянган төгрөгийн хүнс зарцуулж нэг хүүхэд өдөрт дунджаар 2381 төгрөгийн хүнс зарцуулж нормативаас 66 төгрөгөөр илүү олгож 2314.3 мянган төгрөгийн үргүй зардал гаргаж Засгийн газрын 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолын “Хоолны зардлын дундаж норматив батлах тухай” тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Аудитын явцад дотуур байрны жижүүрийн дэвтрээс түүвэр хийхэд 54 хүүхэд илүү, 15 хүүхэд дутуу бүртгэсний зөрүүгээр нийт 39 хүүхдээр илүү тооцож 90.3 мянган төгрөг хүнс илүү зарцуулсан зөрчил илэрсэнд төлбөрийн акт бичлээ. Тухайлбал жижүүрийн ажлын тэмдэглэлийн дэвтрийн 2016 оны 02 дугаар сарын 27-нд 104 хүүхэд дотуур байранд хонов’ гэсэн тэмдэглэл байхад 119 хүүхдээр бүртгэж 15 хүүхэд илүү, 09 дүгээр сарын 02-нд 184 хүүхэд дотуур байранд хонов’ гэсэн тэмдэглэл байхад 188 хүүхдээр бүртгэж 4 хүүхэд илүү, 09 дүгээр сарын 27-нд 185 хүүхэд дотуур байранд хонов’ гэсэн тэмдэглэл байхад 195 хүүхдээр бүртгэж 10 хүүхэд илүү, 09 дүгээр сарын 28-нд 192 хүүхэд дотуур байранд хонов’ гэсэн тэмдэглэл байхад 194 хүүхдээр бүртгэж 2 хүүхэд илүү, 10 дугаар сарын 31-нд 57 хүүхэд дотуур байранд хонов’ гэсэн тэмдэглэл байхад 78 хүүхдээр бүртгэж 21 хүүхэд илүү, 11 дүгээр сарын 03-нд 95 хүүхэд дотуур байранд хонов’ гэсэн тэмдэглэл байхад 97 хүүхдээр бүртгэж 2 хүүхэд илүү, 11 дүгээр сарын 27-нд 137 хүүхэд дотуур байранд хонов’ гэсэн тэмдэглэл байхад 125 хүүхэдээр бүртгэж 12 хүүхэд дутуу, 12 дугаар сарын 12-нд 186 хүүхэд дотуур байранд хонов’ гэсэн тэмдэглэл байхад 183 хүүхэдээр бүртгэж 3 хүүхэд дутуу бүртгэсэн зэрэг зөрчилүүд байна.

Дээрх хүүхдийн ирцийн зөрүү гарсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дахь “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.5 дахь “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно”, 13.6 дахь “Анхан шатны баримтын бүрдэлт, үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7 дахь “Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгахыг хориглоно”. гэсэн заалтуудыг зөрчиж хэрэгжүүлэн ажиллаагүй байгууллагын бүртгэлээр тавих дотоодын хяналтыг сулруулсан байна.

Туслах аж ахуйгаас байрны хүүхдийн хоол хүнсэнд зориулж 1 хязаалан үхэр, 38 хонь гаргаж, мал амьтдын нядалгааны акт үйлдэж, нядалгаанаас гарсан мах, гэдэс, нэхий ширний үнэ нийт 3961.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлэхдээ тус байгууллагын төрийн сангийн 041415101 тоот дансны хүнсний зардлаас гаргаж, 041415101 тоот дансны орлогод тушаасан. 2016 оны 11

сарын 30-нд зөвхөн махны үнэ 3794.3 мянган төгрөгийг өөрийн орлогод шилжүүлж, нэхий шир, гэдэсний үнэ 167.0 мянган төгрөгийг тухайн оны орлогод тушаагаагүй, 2017 оны 02 сарын 10-нд 146.0 мянган төгрөгийг тушааж 21.0 мянган төгрөгийг дутагдуулсан зөрчилд төлбөрийн акт бичлээ.

Мөн 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн иргэн Г.Даваасүрэнгээс худалдан авсан 2896.0 мянган төгрөгийн махыг нярав хүнсний тайланд орлого авч зарцуулсан ч махны үнээс 393.6 мянган төгрөгийг дутуу шилжүүлэн өглөг үүсгээгүй тооцоо нийлж баталгаажуулаагүй жилийн эцсийн тайлан бүртгэлд тусгаагүй зөрчилд аудитын байгууллага тухайн хүнд нь төлж барагдуулахаар төлбөрийн акт тогтоосныг 2016 оны 05 сарын 26-нд уг өрийг барагдуулсан байна.

Үдийн цай: Боловсрол соёл шинжлэх ухаан, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалд “Сургууль эмнэлгийн захиргаа, эцэг эхийн хорооны төлөөлөл бүхий хяналтын зөвлөл байгуулна”, “байнгын хяналт тавьж илэрсэн дутагдал, зөрчлийг дор бүр нь сургуулийн захиргаанд тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасны дагуу сургуулийн дотуур байрны хоол хүнс, үдийн цайны чанар аюулгүй байдалд хяналт тавих, хоол хүнсний хангамж, чанарын асуудлаар ирүүлсэн гомдол хүсэлтийг шийдвэрлэх зорилгоор сургуулийн хяналтын зөвлөлийг 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, зөвлөлийн ажиллах журмыг боловсруулан баталсан байна. Үдийн цайны хоолны цэсийг 7 хоног бүрээр баталж хүүхэд багш нараас үдийн цайны амт чанарын талаар санал авч ажилласан байна.

Үдийн цайг сургуулийн гал тогоонд түшиглэн олгохгүй “Өрнөх-учралт” ХХК, “Ивээлт Булган” ХХК, “Элбэг-эд” ХХК, иргэн Д.Ганцэцэг нартай гэрээ хийн олгож байна.

2016 онд үдийн цай хөтөлбөрт 54819.4 мянган төгрөгийг 91365 хүүхэд өдөр олгохоор төлөвлөн гүйцэтгэлээр 53553.3 мянган төгрөгийг 89255 хүүхэд өдөрт олгож нэг хүүхэд өдөрт 600 төгрөгийн хоол цай олгожээ.

1.3 Төсвийн тухай хуулийн 44.3 дахь заалтыг зөрчин цалинд 3898.3, НДШ-д 818.6 мянган төгрөгийг төсвөөс туслах аж ахуйд зарцуулсан зөрчил байна.

Туслах аж ахуйдаа оны эхэнд 7800.0 мянган төгрөгийн 252 толгой хонь, 1050.0 мянган төгрөгийн 5 толгой үхэр, 200.0 мянган төгрөгийн 1 толгой адуу байснаас 1160.0 мянган төгрөгийн 58 толгой хурга, 50.0 мянган төгрөгийн 1 тугал, бойжуулж, тушаалаар болон аж ахуйд 1355.0 мянган төгрөгийн 33 толгой хонь хэрэглэж, 1935.0 мянган төгрөгийн 47 хонь, 400.0 мянган төгрөгийн 1 үхэр худалдсаж, нас дэвшилтийн сүргийн эргэлт хийснээр оны эцэст 7130.0 мянган төгрөгийн 230 толгой хонь, 950.0 мянган төгрөгийн 5 толгой үхэр, 200.0 мянган төгрөгийн 1 адуу болж нийт малын тоо өмнөх оноос хонь 22 толгойгоор буурсан байна.

Малчины цалинг туслах аж ахуйн орлого оруулан төсөвт төлбөр хураамжийн зардлаас цалинжуулахаар батлуулсан ч 2016 онд 38 хонийг 3106.8 мянган төгрөгөөр, 1 үхрийг 740.5 мянган төгрөгөөр, 9 хонийг 748.7 мянган төгрөгөөр худалдан борлуулж нийт 4543.0 мянган төгрөгийн орлого оруулж, 3898.3 мянган төгрөгийг цалинд олгож төсвөөс 3898.3 мянган төгрөгийг зарцуулсан, мөн нийгмийн даатгалын шимтгэл 818.6 мянган төгрөгийг цалингаас бодож суутгасан ч нийгмийн даатгалын зардлаас шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 44.3 дахь “Үндсэн үйл ажиллагааны зардлаас туслах үйл ажиллагаанд зориулж шууд болон шууд бусаар хөрөнгө зарцуулахыг

хориглоно.” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна. Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар удаа дараа төсвөөс туслах аж ахуйд хөрөнгө зарцуулахгүй байх зөвлөмж өгч байсан ч хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Туслах аж ахуйн жилийн эхэнд 252 хонины 43.6 хувь, жилийн эцсийн нийт 230 хонины 49.1 хувь нь эр мал байгаа нь сүргийн бүтцийг сайжруулж, ашигтай ажиллуулах, сүргийн эргэлтийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй мөн малын үнэлгээ зах зээлийн үнээс хэт бага байна. Тухайлбал нас гүйцсэн эр хонь 45.0, эм хонь 35.0 мянган төгрөг байгаа нь зах зээлд зарагдаж байгаа махны үнэтэй харьцуулбал 50 хувь хямд үнээр тайлан, бүртгэлд тусгагджээ. Цаашид малын үнийг зах зээлийн үнээр үнэлэх шаардлагатай байна.

1.4 Төсөл хөтөлбөрийн талаар: 2016 онд Нэмэлт санхүүжилтийн дансанд дараах орлогууд орж ирсэн.Үүнд:

- заалны орлого – 680.0
- байрны түрээс – 1026.2
- байрны засварын хандив – 1292.0
- хашааны хайсны үнэ – 300.0
- 2015 оны төвлөрүүлэлт – 780.4
- төсөл хөтөлбөр – 4786.8
- андуурагдсан – 1200.0
- гүнзгий ангийн төлбөр- 37.6
- нэр данс зөрүүтэй орлого 2027.0 мянган төгрөг нийт 12140.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

1. 2015 онд тус сургуулийн 90 жилийн ойн арга хэмжээнд зарцуулагдсан 87 кг махны үнэ 565.5 мянган төгрөгийг Л.Оюунтуяад, талхны үнэ 54.0 мянган төгрөгийг С.Оюунчимэгт, боовны үнэ 54.0 мянган төгрөгийг Дэлгэрэх фүүдсэд, хүнсний материалын үнэ 507.2 мянган төгрөгийг Булган Сэлэнгэ ХХК-д нийт 1180.7 мянган төгрөгийг санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй байтал нэмэлт санхүүжилтийн данснаас олгосон байна.

2. Эрдэнэбармат ХХК-аас 1019.2 мянган төгрөг, иргэн С.Отгонбаяраас 742.2 мянган төгрөгийн засварын материал нийт 1761.5 мянган төгрөгийг барилгын засварын материалд зарцуулсан.

3. Хүлэмж барихад плёнка, чайна ажлын хөлс зэрэгт нийт 470.0 мянган төгрөг, шинээр барих жорлонгийн нүх ухуулахад 300.0 мянган төгрөг, гүнзгий ангид шугам гортигний ком 37.6 мянган төгрөг, байгалийн ухааны кабинетийн шкаф тавиурт 1000.0 мянган төгрөг нийт 2277.6 мянган төгрөгийг зарцуулсан байна.

4. Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд Дэлхийн банкны 6.0 сая төгрөгний төсөл зарлагдаж, тус сургуулийн “Бага ангийн байгалийн ухааны кабинет” төсөл нь шалгарч эхний ээлжинд 80%-ийг санхүүжүүлэхээр болж 2016 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Боловсрол соёл урлагийн газраас 4786.8 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт орж ирсэн. Төслийг хэрэгжүүлэхээр “Сүлдэт говь” ХХК, “Өгөөмөр Мон Тех” ХХК-ууд үнийн саналаа ирүүлснээс тус төслийн хэрэгжүүлэх ажлын хэсгийн хуралдаанаас “Өгөөмөр Мон Тех” ХХК-ийг сонгон гэрээ байгуулж хамтран ажиллахаар

шийдвэрлэсэн байна. Нийт 61 нэр төрлийн 4786800 төгрөгийн тоног төхөөрөмж авч, тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгө болон бараа материалаар нь ялган бүртгээгүй төсвөөс гарсан нийт дүнгээр нь бусад материал дансанд орлогодсон зөрчилтэй байгаа тул тоног төхөөрөмжийг нэр төрлөөр нь данс бүртгэлд тусгахаар албан шаардлага бичлээ.

Тоног төхөөрөмж худалдан авах жагсаалтыг хүснэгтээр харуулбал:

/ Төлөвлөгөө гүйцэтгэл/

№	Тоног төхөөрөмжийн нэр, төрөл, хэмжээ	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	тайлбар
1	Электрон жин	2	40000	80000	
2	Хуруун шил 15*150, 16*125, 24*200	39	5000	195000	
3	Штатив, хавчаарын ком	3	50000	150000	
4	Хямсаа	11	2000	22000	
5	Конусан колбо /100 мл/	1	5000	5000	
6	Конусан колбо /250 мл/	5	5000	25000	
7	Туухай ком,жин	1	55000	55000	
8	Термометр /цагаан/	10	7000	70000	
9	Термометр /улаан/	10	7000	70000	
10	Хуванцар нэрмэл усны сав	9	4500	40500	
11	Индикатор /улаан/	10	5000	50000	
12	Индикатор /цагаан/	10	5000	50000	
13	Спиртэн дэн	10	15000	150000	
14	Цахилгаан халаагуур	1	50000	50000	
15	Уур нүдүүр	7	9000	63000	
16	Анолог дэлгэцтэй тогтмол үйлдлийн амперметр	3	20000	60000	
17	Анолог дэлгэцтэй хувьсах үйлдлийн амперметр	3	20000	60000	
18	Дэлгэцтэй ачааны ком	3	25000	75000	
19	Гэрлийн хугарал, ойлт сарнилыг үзүүлэх багаж	1	95000	95000	
20	Соронзон /шулуун/	15	7000	105000	
21	Соронзон орон /диамонд хэлбэрийн/	2	35000	70000	
22	Электроскоп	1	95000	95000	
23	Шилэн саваа	10	6000	60000	
24	Хуванцар саваа	10	6000	60000	
25	Сор жигүүртэй	5	15000	75000	
26	Биеийн тэнцвэрт байдал үзүүлэх багаж	2	45000	90000	
27	Физикийн ижил эзлэхүүнтэй биетүүд иж бүрдэл	2	20000	40000	
28	Нар сарны хиртэлт үзүүлэх багаж	1	90000	90000	
29	Хөшүүрэг төрөл бүрийн тэнцвэрийг судлах багаж	3	20000	60000	
30	Динамометр	3	15000	45000	
31	Томруулагч линз хүнхэр гүдгэр толь	10	8000	80000	
32	Цахилгааны 2 туультай түлхүүр	10	18000	180000	
33	Батарей	20	3500	70000	
34	Луужин	19	7000	133000	
35	Цахилгаан холболтын утас	10	4000	40000	
36	Тархины бүтэц	3	35000	105000	
37	Хүний биеийн араг яс	1иж бүрдэл	350000	350000	

38	Чихний бүтэц, алх дөш	1иж бүрдэл	50000	50000	
39	Нүдний бүтэц 3309	1	65000	65000	
40	Нүдний бүтэц 3326	1	50000	50000	
41	ДНХ загвар	1иж бүрдэл	53000	53000	
42	Хүний үр хөврөлийн хөгжил 8ш	1иж бүрдэл	180000	180000	
43	Ургамлын үндэсний дотоод бүтэц	1	65000	65000	
44	Цэцэг	1	25300	25300	
45	Цэцэг мод тайрагч хайч	5	10000	50000	
46	Үет ургамлын анги 33008	1	25000	25000	
47	Эстэн шаахай	1	25000	25000	
48	Үр суулгах сав	20	1000	20000	
49	Микроскоф/чемодантай/	1	300000	300000	
50	Бүрхүүл шил	10	5000	50000	
51	Тавиур шил	10	5000	50000	
52	Хямсаа төмөр	10	2000	20000	
53	Пипитек	30	1000	30000	
54	Шил сав мензурк	10	5500	55000	
55	Глобус Дэлхийн улс	2	75000	150000	
56	Глобус уртраг өргөрөг	1	90000	90000	
57	Термометр төрөл бүр	5	10000	50000	
58	Биосфер түүний хил хязгаарыг харуулсан цахилгаан самбар 3421	1	200000	200000	
59	Дэлхий дээрх кодесацын үзэгдэл, бороо үүсэх үзэгдэлхаруулах цахилгаан самбар 3422	1	200000	200000	
60	Салхи хэмжих багаж	1	65000	65000	
61	Шугам ком	1ком	35000	35000	
	Нийт дүн			4786800	

Нэмэлт санхүүжилтийн дансаар урьд оны хэмнэгдсэн төсвийн үлдэгдэл 780.4 мянган төгрөг орж ирснийг сургууль болон дотуур байрны засварын материалд зарцуулсан байна.

Бүлэг 2

Дотоод хяналт үр нөлөөтэй байна уу.

2.1 Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 19 удаагийн 45.5 сая төгрөгийн гүйлгээнээс 43.9 сая төгрөгийн мэдээллийг цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансны тухай хууль нь 2015 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байна. Энэ хуулийн зорилго нь улс, орон нутгийн төсөв, улсын болон орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор, тухайн байгууллагын үйл ажиллагаа иргэдэд ил тод, нээлттэй, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог бүрдүүлэхэд оршдог.

Хуулиар шилэн дансны мэдээллийг нэгдсэн цахим хуудас, байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах болон бусад хэлбэрээр үнэн зөв, иж бүрэн, тогтоосон хугацаанд иргэд олон нийтэд мэдээлэх ёстой.

Шилэн дансны мэдээлэл байршуулсан байдлыг 2017 оны мэдээллийг шалгаж тавьсан болно.

Тус хуулийн 6.1-д заасан мэдээллийг тогтмол мэдээлэх бөгөөд ерөнхий боловсролын сургуулийн хувьд тухай жилийн төсвийг, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, бусад 3 цэсний мэдээллийг сар бүр байршуулсан ч 12 дугаар сарын мэдээллийг мэдээлээгүй байна. Өмнөх оны төсвийн зарлагын хэмнэлт, туслах үйл ажиллагаанаас давсан хэсгийг урамшуулалд зарцуулсан тайлан, хандив тусламжийн хэмжээ түүний зарцуулалт, санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, худалдан авах ажиллагааны тайлан зэрэг бүтэн жилээр 1 удаа тавигдах мэдээллийг байршуулаагүй байна.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээг 7 хоногийн дотор мэдээлэхээр заасан бол тус сургуулийн хувьд 35 удаагийн 1744.3 сая төгрөгийн орлогын, 316464.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ гарсныг мэдээлж 12 сарын орлого зарлагын гүйлгээг цахим хуудсанд мэдээлж байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг тухай бүр 7 хоногийн дотор мэдээлэхээр заасныг сургуулийн хувьд 19 удаагийн 45573.9 мянган төгрөгийн гүйлгээ гарсанаас 10-20%-ийн нэмэгдэл цалин олгох 7 тушаал, 1574.6 мянган төгрөгийн 4 гүйлгээг мэдээлж, 15 удаагийн 43999.3 мянган төгрөгийн гүйлгээг цахим хуудсанд мэдээлж байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8, 6.8.1-д заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Булган аймаг СХААлба

12

Ү

☉ ☉☉

☉ ☉

**Дүгнэлт
Зөвлөмж**

Дотуур байрны хүүхдийн өдөрлөгийг 103 хүүхэд өдрөөр илүү бичиж хүнс зарлагдсан, туслах аж ахуйд төсвөөс хөрөнгө зарцуулсан зэрэг зөрчил илэрлээ.

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Төсвийн шууд захирагч нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэснийг мөрдөн ажиллаагүй,
- Туслах аж ахуйн малчинд төсвөөс цалин олгодог, Төсвийн тухай хуулийн 44.3 дахь заалтыг хэрэгжүүлээгүй, зөрчсөн
- Сургуулийн дотуур байрны хүүхдийн өдөрлөгийг 39 хүүхэд өдрөөр илүү бичиж 90.3 мянган төгрөгийн хүнсний материал илүү зарцуулсан,
- Шилэн дансны тухай хуулийн 6.4.5, 6.3.5 заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй,
- Нярав 80.0 мянган төгрөгийн модем, 59.0 мянган төгрөгийн засварын материалыг орлогодоогүй, тайланд бүртгэлд тусгаагүй.
- Хүнс материалын үнэ төлөхдөө дутуу шилжүүлж өглөг үүсгэн тооцоо нийлж баталгаажуулаагүй байж дараа дараагийн онд нь шилжүүлж шууд зардал болгон бүртгэж байна.
- Үндсэн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэж тайлагнасан.
- Нэмэлт санхүүжилтийн дансанд орсон орлогоос мөн 90 жилийн ойд зарцуулсан хүнсний материалын өглөгийг өгч барагдуулсан, төслөөр авсан тоног төхөөрөмжийг үнийн дүнгээр бараа материалд бүртгэсэн зэргийг үндэслэн төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлтгүй, үрэлгэн зарцуулсан, хөрөнгийн зарцуулалт, бүртгэл хөтлөлтөнд тавих дотоодын хяналтыг сулруулсан байна гэж дүгнэлээ.

ЗӨВЛӨМЖ: Аудитын шалгалтаар гарсан зөрчлийг арилган, дахин давтан гаргахгүй байхад анхааруулж, ажил сайжруулах зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллах.

НЭГДҮГЭЭР БҮРЭН ДУНД СУРГУУЛИЙН ЗАХИРАЛД

- Хичээл үйлдэрлэлийн зардлаас шагнал, урамшуулал тэмдэглэлт баярт зориулж хөрөнгө зарцуулдаг байдлыг хязгаарлах.
- Туслах аж ахуйд зориулж төсвөөс хөрөнгө зарцуулдаг явдлыг таслан зогсоох.
- Бараа материал, хүнсний материалын зарцуулалтанд тавих санхүүгийн болон дотоод хяналтын сайжруулах,
- Нягтлан бодох бүртгэлийн болон төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа бүрэн мөрдөж ажиллах.
- Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байгууллагатай холбоотой мэдээллийг тогтмол байршуулж хэвших.

- Бараа материалын дансанд тусгасан үндсэн хөрөнгийг бүртгэл тайланд залруулан бүртгэх арга хэмжээ авч ажиллах.

МЭДЭГДЭЛ:

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалттай арга хэмжээ авч 2018 оны 03 дүгээр сарын 10-ны дотор ирүүлэхийг мэдэгдье.

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН
АХЛАХ БАЙЦААГЧ Д.САРАНГЭРЭЛ

ТАЙЛАН БИЧСЭН:

ТАНИЛЦАЖ ЗӨВШӨӨРСӨН:

СХШУБАЙЦААГЧ

О.ГАНТУЯА

ЗАХИРАЛ
ЗАХИРАЛ АСАН
НЯ-БО

Д.ЗООСҮРЭН
Л.ГЭРЭЛТУЯА
З.СУВД-ЭРДЭНЭ

